

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ОРЧИНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ, ШИЙДВЭРЛЭХ АСУУДАЛ

С.Болортуяа

ДХИС-ийн Удирдлагын академийн 22-7081 дүгээр дамжааны суралцагч

Товч агуулга: Энэхүү судалгаа нь төрийн байгууллагын орчныг тодорхойлох нөлөөлөх хүчин зүйлийг судалж албаны албан хаагчдын дунд тулгамдаж байгаа асуудлын хүчин зүйлүүдийг тодорхойлохыг зорьсон. Судалгаанд нийт 265 оролцогчийн өгөгдөлд боловсруулалт хийж шинжлэн, SPSS-23.0 программ хангамжийг ашиглаж, байгууллагын орчны хүчин зүйлийн шинжилгээг хийсэн.

Түлхүүр үг: Байгууллагын орчин, дотоод гадаад орчин, SWOT PEST шинжилгээ

Судалгааны ажлын үндэслэл, судлагдсан байдал

Аливаа байгууллагын үйл ажиллагаа макро болон микро орчинд нөлөөлж байгаа асуудлууд нь гадаад, дотоод орчны хүчин зүйлээс хамаарна.

Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт, Төрийн албаны тухай хууль /шинэчлэн/, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт менежментийн үйл ажиллагаа, орчны талаар дараах байдлаар тусгасан. Үүнд:

- Нийгмийн бүх түвшинд шударга ёсыг бэхжүүлэх бодлогын болон хууль, эрх зүйн орчин бүрдсэн байна.

- Хууль эрх зүйн тогтвортой орчинтой, хотын дүрэм стандартыг хангуулсан сайн засаглалтай хот болно гэж тусгагдсан нь энэхүү сэдвийг судлах, байгууллагын орчин нийгэмтэйгээ харилцан хамааралтай байх үндэслэлийг тодорхойлсон.

Нийгмийн шинжлэх ухааны салбарт байгууллагын гадаад дотоод

орчны уялдаа харилцан хамаарал хүчин зүйлийн эерэг сөрөг нөлөөллийг авч үзсэн.

Байгууллагын үйл ажиллагааны орчныг судлахдаа, онол арга зүйд суурилж үндсэн агуулгыг байгууллагын дотоод гадаад орчин талаас SWOT PESTLE нэр томъёоны анхны ишлэлд 1967 онд хэвлэгдсэн Фрэнсис Агилар¹ын “Корпорацын орчныг судлах” номоос эхтэй.

PEST шинжилгээ (улс төр, эдийн засаг, нийгэм, технологийн) нь байгууллага зах зээлд илүү өрсөлдөх чадвартай болохын тулд үйл ажиллагаанд нь нөлөөлж буй гадаад гол хүчин зүйлсийг үнэлж дүгнэх менежментийн арга ². PEST шинжилгээний үргэлжлэл болох түгээмэл хувилбар болох PESTLE стратеги төлөвлөлтийн арга нь Их Британид хууль эрх зүйн болон байгаль орчны нэмэлт асуудлуудыг багтаасан

¹ <https://www.irjet.net/archives/V3/i1/IRJET-V3I165.pdf>


² <https://www.irjet.net/archives/V3/i1/IRJET-V3I165.pdf>

байдгаараа онцлог ¹ (RastogiNitank, 2016).

Судалгааны ажлаараа энэхүү загварын улс төр, эдийн засаг, нийгэм, технологийн хүчин зүйлийг хувьсагч

болгон сонгон авч байгууллагын гадаад орчинд хэрхэн нөлөөлөх нөлөөллийн хамаарлыг таамаглал дэвшүүлэн судаллаа.

Зураг 1. Судалгааны ажлын таамаглал



Тайлбар: Судлаачийн санал болгож буй загвар

Судалгааны үр дүн


Бидний судалгааны ажилд төрийн байгууллагын төлөөлөл болсон Улсын онцгой комисс, Онцгой байдлын алба, Хил хамгаалах байгууллага, Цагдаагийн ерөнхий газрын алба хэлтэс, Баянзүрх дүүргийн соёлын ордон зэрэг байгууллагын удирдах, гүйцэтгэх, үйлчлэх албан хаагчдаас бүрдсэн нийт **265** оролцогч хамрагдсан нь судалгааны ажлын сэдвийн хүрээнд төлөөлөл болох боломжтой гэж үзэж байна.

Чанарын судалгааны арга зүй гэдэг нь хувь хүн эсвэл бүлгийн утга учир, нөхцөл байдал, туршлагыг ойлгох, тайлбарлахад чиглэгдсэн шинжлэх ухааны судалгаанд чиглэсэн арга зүй. Энэхүү арга зүй нь хүчин зүйлийн субъектив шинж чанарыг онцолж, судалгааны асуултад шууд болон шууд бус хамааралтай мэдээллийг олж илрүүлэх зорилготой тул сонгосон.

Судалгааны ажлын боловсруулалт, үр дүн

¹

<https://www.cipd.org/uk/knowledge/factsheets/pestle-analysis-factsheet>

Зураг 2. Судалгааны ажлын хэмжил зүйн шинжилгээ

Тайлбар: pol-улс төрийн хүчин зүйл, ec-эдийн засгийн хүчин зүйл, sc-нийгмийн хүчин зүйл, te-технологийн хүчин зүйл, OR EN-байгууллагын орчин

Хүснэгт 1. Хамаарлын шинжилгээ

Хүчин зүйл	Байгууллагын гадаад	Нийгмийн хүчин	Технологийн хүчин	Улс төрийн	Эдийн засгийн
------------	---------------------	----------------	-------------------	------------	---------------

Байгууллагын орчинд технологийн хүчин зүйл 0.548 тоон утга бүхий үр дүнгээр хамаарал өндөртэй байгааг илэрхийлж байна.

Технологийн хүчин зүйл нь улс төрийн хүчин зүйлтэй 0.314 тоон утгаар

	Дорчин	Зүйл	Н зүйл	Хүчин зүйл	Н хүчин зүйл
Байгууллагын гадаад орчин	0.570				
Нийгмийн хүчин зүйл	0.263	0.546			
Технологийн хүчин зүйл	0.548	-0.175	0.550		
Улс төрийн хүчин зүйл	0.423	-0.050	0.314	0.762	
Эдийн засгийн хүчин зүйл	0.290	-0.059	0.157	0.228	0.743

Тайлбар: Судалгааны ажлын үр дүн

дундаж хамааралтай байгааг илэрхийлж байна.

Улс төрийн хүчин зүйл ба эдийн засгийн хүчин зүйл 0.228 тоон утга бүхий бага хамааралтай байгааг илэрхийлж байна.

Хүснэгт 2. Замын шинжилгээ

Таамаглал	Дундаж утга	Стандарт хазайлт	T статистик	П үнэцэн	Үр дүн
Нийгмийн хүчин зүйл ► Байгууллагын орчин	0.021	0.240	0.701	0.483	батлагдаагүй
Технологийн хүчин зүйл ► Байгууллагын орчин	-0.362	0.272	1.528	0.127	

Улс төрийн хүчин зүйл ► Байгууллагын орчин	-0.244	0.188	1.319	0.188	
Эдийн засгийн хүчин зүйл ► Байгууллагын орчин	-0.161	0.230	0.689	0.491	

Тайлбар: Судалгааны ажлын үр дүн

Бидний судалгааны ажилд, таамаглал болгон дэвшүүлсэн дөрвөн таамаглалын хувьд дундаж уга -0.161-0.021 тоон утгын хооронд, стандарт хазайлт 0.188-0.272 тоон утгын хооронд, Т статистик 0.689-1.528 тоон утгын хооронд тус тус хэлбэлзэж байна.

Судалгааны ажлаараа дэвшүүлсэн дөрвөн таамаглал замын шинжилгээгээр батлагдаагүй.

Дүгнэлт

Байгууллагын орчин нь байгууллагын соёл, гүйцэтгэл, нийт амжилтыг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд манлайлагчид түүний динамикийг ойлгож, түүнд дасан зохицоход чухал үүрэг гүйцэтгэдэг;

Байгууллагын орчинд нөлөөлж буй тухайн байгууллагын үйл ажиллагаа явуулж буй нөхцөл байдлыг илэрхийлдэг бөгөөд энэ нь түүний эрхэм зорилго, алсын хараа, стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд улс төр, эдийн засаг, нийгэм, технологийн хүчин зүйл нь манай төрийн байгууллагуудын хувьд дундаж түвшинд хүрэхгүй байгааг судалгааны ажлын шинжилгээ харуулсан.

Санал

Судалгааны ажлаараа дараах хоёр саналыг дэвшүүллээ. Үүнд:

Байгууллагын гадаад орчныг тодорхойлогч дөрвөн хувьсагч энэ удаагийн судалгааны үр дүнг бүрэн илэрхийлээгүй тул давтан судалгаа авах, шинжлэх, үр дүнг нэгтгэх

Хувьсагчийг нэмэн олон улсын жишиг судалгаатай харьцуулах зэрэг болно.

Эх сурвалжийн жагсаалт

- Г. Гантөгс “Хүний нөөцийн менежмент” 2014, УБ хот,
- Н. Оюунжаргал “Хүний нөөцийн менежмент” сурах бичиг 2013 он, УБ хот,
- Б. Мөнхжаргал, Б. Амаржаргал “Менежмент” 2013 он, УБ хот,
- Ө. Өлзийбалсан “Хүний нөөцийн удирдлага” 2014 он, УБ хот,
- П. Увш, Б. Хэрлэн “Байгууллагын зан үйл” 2004он, УБ хот,
- Ларри Стаут “Хүний нөөцийн удирдлага” орчуулсан С. Давааням, С. Дулмаа 2009 он, УБ хот,
- Г. Цэрэн “Байгууллагын зан төлөв” 2014 он, УБ хот,
- Ц.Цэцэгмаа “Хүний нөөцийн менежмент” онол, практик, жишээ 2009 он, УБ хот,
- П. Наранцэцэг “Хүний нөөцийн менежмент ” 2014 он, УБ хот,
- Н.Цэнд, Г.Батхүрэл, Я.Шуурав, Х.Пүрэвдавга, Ц.Цэцэгмаа, Н.О.Лизунов, Л.Цэрэнчимэд, Д.Оюунчимэг “Менежмент” сурах бичиг 2013 он, УБ хот,
- Х. Пүрэвдавга, Г. Батхүрэл “Хүний нөөцийн менежмент” сурах бичиг 2015 он, УБ хот,
- Training Personal Confidence and Motivation, year 2013, chapter 3, p-20

- Work Motivation History, Theory, Research and Practice, publications, London 2007,

- Drafke, M. W. & Kossen, S. (2002). The human side of organizations, 8th Edition, pp. 287.

- Fernandes, F. N. (1998). Total Reward-An Actuarial Perspective. Actuarial Research Paper, No.116.

- Manmohan Joshi 'Human Resource Management' 2013, p-88

- C.A Myers, industrialism and Industrail man, Harvard University, press,1980, p11-12

- Appeldorn, R. H. Technology Transfer in a Diversified, Global Manufacturing Company. 2008.

- "CYBER SOLUTIONS HANDBOOK" Making Sense of Standards and Framework, 2014

Судалгааны ажлын хавсралт

S Bolor.txt

*S.Bolortuya 2023.splsm

PLS Algorithm (Run No. 1)

Bootstrapping (Run No. 1)

Path Coefficients

Mean, STDEV, T-Values, P-Values

Confidence Intervals

Confidence Intervals Bias Corrected

Samples

Copy to Clipboard:

	Original Sampl...	Sample Mean (...)	Standard Devia...	T Statistics (O /...	P Values
Нийгмийн хүчин зүйл -> БАЙГУУЛЛАГЫН ГАДААД ОРЧИН	0.168	0.021	0.240	0.701	0.483
Технологийн хүчин зүйл -> БАЙГУУЛЛАГЫН ГАДААД ОРЧИН	-0.416	-0.362	0.272	1.528	0.127
Улс төрийн хүчин зүйл -> БАЙГУУЛЛАГЫН ГАДААД ОРЧИН	-0.248	-0.244	0.188	1.319	0.188
Эдийн засгийн хүчин зүйл -> БАЙГУУЛЛАГЫН ГАДААД ОРЧИН	-0.158	-0.161	0.230	0.689	0.491